

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/29/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Долгорсүрэн Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn Аудитор: Ж.Нямцэцэг Утас: 261628 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/410
танай _____ -ны № _____ -т

БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ, ХОШУУЧ Э.ДАШРАВЖИР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Багануур тоосго ТӨААТҮГ нь тайлант онд 393000 ширхэг тоосго, 2219 ширхэг хөнгөн блок, 8606 ширхэг нүхтэй блок үйлдвэрлэж, 427 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 15 га талбайд төмс хүнсний ногоо тариалж, 48.5 тонн хүнсний ногоо хураан авсан байна.

Барилгын материалын зах зээлд нягт багатай, том хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой, хөнгөн, нарийн жигд бүтэцтэй, бат бөх, дуу, дулаан тусгаарлах ба хадгалах чанар өндөр, ус чийгт норж дэвтэхгүй, хүний эрүүл мэндэд хоргүй, галын аюул багатай, өрлөгийн ажлыг хэд дахин хурдасгах боломжтой төрөл бүрийн блок гарсан нь тоосгоны эрэлтийг бууруулж, үйлдвэрлэсэн тоосго борлогдохгүй, үлдэгдэл өсөхөд нөлөөлсөн байна.

Тус үйлдвэр зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан хөнгөн блокны үйлдвэрийн ажлыг эхэлж, 2219 ширхгийг үйлдвэрлэж борлуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус үйлдвэр тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 171.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 218.0 сая төгрөгийг зарцуулж, 46.7 сая төгрөгийн алдагдалтай гарсан боловч ШШГЕГ-т 15.0 сая төгрөгийг төвлөрүүлсэнээр алдагдлын хэмжээ өсөж 61.7 сая төгрөгт хүрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 70 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022 оны12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	3,809,516.66	4,370,594.09
1.1.04	Бусад авлага	57,878,500.00	27,642,850.50
1.1.06	Бараа материал	112,301,220.44	148,937,102.30
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	173,989,237.10	180,950,546.89
1.2.01	Үндсэн хөрөнгө	240,377,504.47	180,543,809.41
1.2.02	Биет бус хөрөнгө	283,333.42	21,794.98
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	240,660,837.89	180,565,604.39
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	414,650,074.99	361,516,151.28
2.1.1.03	Татварын өр	41,263.59	8,532,918.26
2.1.1.13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	41,263.59	8,532,918.26
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	95,910,070.00	-
2.1.2.06	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	95,910,070.00	-
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	95,951,333.59	8,532,918.26
2.3.01	Өмч: - төрийн	192,291,669.83	192,291,669.83
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	117,668,893.04	213,578,963.04
2.3.09	Хуримтлагдсан ашиг	8,738,178.53	(52,887,399.85)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(61,625,578.38)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	8,738,178.53	8,738,178.53
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	318,698,741.40	352,983,233.02
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	414,650,074.99	361,516,151.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	251,887,622.31	171,310,064.92
2	Борлуулалтын өртөг	119,510,384.95	92,291,669.19
3	Нийт ашиг (алдагдал)	132,377,237.36	79,018,395.73
4	Түрээсийн орлого	4,518,181.78	-
8	Бусад орлого	-	35,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	53,415,400.51	125,678,974.11
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(18,194.44)	-
17	Бусад ашиг (алдагдал)	1,021,804.08	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	84,483,628.27	(46,625,578.38)
19	Орлогын татварын зардал	444,836.28	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	84,038,791.99	(46,625,578.38)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	40,000,000.00	(15,000,000.00)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	192,291,669.83	117,668,893.04	(35,300,613.46)	274,659,949.41
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	192,291,669.83	117,668,893.04	(35,300,613.46)	274,659,949.41
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	44,038,791.99	44,038,791.99
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	192,291,669.83	117,668,893.04	8,738,178.53	318,698,741.40
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	95,910,070.00	-	95,910,070.00
11	Залруулсан үлдэгдэл	192,291,669.83	213,578,963.04	8,738,178.53	414,608,811.40
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(46,625,578.38)	(46,625,578.38)
15	Олгосон ногдол ашиг	-	-	(15,000,000.00)	(15,000,000.00)
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	192,291,669.83	213,578,963.04	(52,887,399.85)	352,983,233.02

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	252,633,695.00	215,562,450.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	245,758,695.00	210,857,450.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	6,875,000.00	4,705,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	226,657,767.61	200,001,372.57
1.2.1	Ажиллагчдад төлсөн	82,821,929.10	100,988,002.39
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,081,453.74	2,418,315.23
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	38,958,885.00	37,572,100.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	25,187,421.40	7,197,500.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	49,020,366.24	26,536,300.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	24,468,362.13	3,421,268.83
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	617,850.00	617,850.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	4,501,500.00	21,250,036.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,975,927.39	15,561,077.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	40,000,000.00	15,000,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	40,000,000.00	15,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(40,000,000.00)	(15,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(14,024,072.61)	561,077.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,833,589.27	3,809,516.66
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,809,516.66	4,370,594.09

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	ХН	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйлдвэрлэл					
1.1	Улаан тоосго	ш	1,000,000	393,000	607,000.0	39.3
1.2	Нүхтэй блок	ш	25,000	8,606	16,394.0	34.4
1.3	Хөнгөн блок	ш		2,219	(2,219.0)	
1.4	Төмс хүнсний ногоо	тн	131.0	48.5	82.5	37.0
1	Борлуулалтын орлого	мян.төг	479,200.0	171,310.1	307,889.9	35.7
2.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	263,655.0	92,291.7	171,363.3	35.0
2.2	Дээд газарт төвлөрүүлэх	мян.төг	40,000.0	15,000.0	25,000.0	37.5
2.3	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	мян.төг	52,836.1	93,948.7	(41,112.6)	177.8
2.4	Ажил олгогчоос НДШ	мян.төг	1,791.8	2,448.1	(656.3)	136.6
2.5	Бараа үйлчилгээ болон бусад зардалд	мян.төг	19,693.6	29,282.2	(9,588.6)	148.7
3	Нийт зарлагын дүн	мян.төг	377,976.5	232,970.7	145,005.8	61.6
4	Ашиг	мян.төг	101,223.5	(61,660.6)	162,884.1	(60.9)
5	Хөрөнгө оруулалт	мян.төг	53,000.0	10,400.0	42,600.0	19.6
6	Ажиллагсдын тоо	хүн	6	5	1	83.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 165.7 сая төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТӨБЗГ-ын 2022.11.22-ны өдрийн 519 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 9 нэрийн хөрөнгийн үнийг 95.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосныг өмнөх онд хойшлогдсон татварын өр төлбөрөөр тайлагнасан байна.	1	95,910.10	-	-	1	95,910.1	1	95,910.1	-	-	-	-
Дээрх дахин үнэлэгдсэн хөрөнгийн тайлант оны элэгдэл 54.8 сая төгрөгийг үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийн орлогын кт-с хойшлогдсон татварын өр дансны Дт-д бичилт хийж орлогын тайланд тайлагнасан байна.	1	54,788.90	-	-	1	54,788.9	1	54,788.9	-	-	-	-
Дээд байгууллагад төвлөрүүлсэн ногдол ашгийн 15.0 сая төгрөгийг орлогын тайланд бусад ашиг, алдагдлаар тайлагнасан байна.	1	15,000.00	-	-	1	15,000.0	1	15,000.0	-	-	-	-
Дүн	3	165,699.0	-	-	3	165,699.0	3	165,699.0	-	-	-	-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

Аудитаар 1 зөрчил² илэрсэнд албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх аудитаар өгсөн орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулах зөвлөмж хөрөнгийн маргааны улмаас хэрэгжээгүй байна.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэх 2 мэдээллийн хугацааг хоцроосон, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-